



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлд:

XIII.58.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн өмчийн барилгын гаднах нийтийн эзэмшлийн байгууламжид засан сайжруулалт хийх зөвшөөрөл олгох тухай.

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороонд байрлах “Элит” төвийн гаднах нийтийн эзэмшлийн байгууламжид “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компаниас Иргэний хууль (94.4, 120.1, 288.2.4, 288.2.1, 332.4 зэрэг заалт)-д нийцүүлэн гэрээ байгуулсны үндсэн дээр засан сайжруулалт хийхийг дэмжив.

Засварын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, засварын ажил бүрэн дуусмагц хянан баталгаажуулах, данснаас хасах хөрөнгийн асуудлыг боловсруулан шийдвэрлүүлэхийг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга Ж.Тамирт даалгав” гэжээ.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР